



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/57

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2012 оны А/113 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 3.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангахад нэн тэргүүнд шаардлагатай хамгаалах хувцас, ариутгал, халдваргүйтгэлийн бодис худалдан авах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд 7.387.850 (долоон сая гурван зуун наян долоон мянга найман зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100125

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 14-ны өдрийн 157 дугаар
захирамжийн хавсралт



**ШИНЭ КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, БЭЛЭН БАЙДЛЫГ
ХАНГАХАД НЭН ТЭРГҮҮНД ШААРДЛАГАТАЙ ХАМГААЛАХ
ХУВЦАС, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИСТ
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Еврофарм ХХК			
Хамгаалалтын нүдний шил	28	3950	110600
Ус нэвтэрдэггүй комбинзон	300	18000	5400000
Хамгаалалтын резинен гутал	32	23500	752000
Нийт			6262600
Увидаст Наран ХХК			
Комбинзон,	12	22600	271200
Ариутгал, халдваргүйтгэлийн бодис	10	22160	221600
И95 маск	20	4000	80000
Нүүрний хамгаалалт	6	4200	25200
Гутлын углааш	12	2000	24000
Нийт			622000
Эм гоо ХХК			
Санитас	65	1300	84500
Тамидин ам зайлах	65	1400	91000
Маск	325	550	178750
Спирт	1	6000	6000
Нойтон сальфетик	65	2200	143000
Нийт			503250